



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 БАГА БОЛОВСРОЛ



МОНГОЛ ХЭЛ

БАГАНАН КОД
НААХ ХЭСЭГ

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:



Засалтын хүснэгт

Даалгаврын дугаар	Авсан оноо	
I		
II		
III		
IV		
V		
VI		
VII		
VIII	A	
	Б	
	B	

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. УНШИХ

Эхийг уншаарай.

Зараа хулгана хоёр

Ногооны талбайн ойролцоо нэгэн зараа амьдардаг байжээ. Тэр зараа найзтай болохыг их хүсдэг байв. Нэгэн өдөр хулганатай таарав.

-Сайн уу? Хулгана минь!

-Сайн уу? Өргөсний уут аа!

-Чи намайг битгий шоолооч дээ. Найзууд больё.

- Найзлахаа? Чи өөрийгөө хар л даа! Энд тэндгүй өргөс. Өөрийнхөө ижлийг л ол гэж хулгана хэлэв.

Зараа: - Би ширүүн үстэй ч сэтгэл минь тийм биш гээд уйлсаар буцлаа.

Нэгэн өдөр зараа ногооны талбайгаас мөөг олоод амтархан идэж байв. Гэнэт ойрхон хэн нэгний тусламж эрэн дуудах нь сонсогдлоо. Зараа хурдхан гүйж очив. Гэтэл могой хулганыг идэхээр ухасхийв. Яг энэ үед зараа бөндөгнөн өнхөрч дундуур нь орлоо. Могой өргөсөнд хатгуулан хулганаас холдов.

1 Зараа юу хүссэн бэ? Сонгож тэмдэглээрэй.

Хулганатай найзлахыг хүссэн.

Амттай мөөг идэхийг хүссэн.

Хэн нэгэнд туслахыг хүссэн.

2 Зургийг ажиглаад, үйл явдлыг асуултын дагуу холбоорой.



Эхлээд юу болсон бэ?



Дараа нь юу болсон бэ?



Эцэст нь яасан бэ

3 Ямар амьтан тусламж дуудсан бэ? Сонгож тэмдэглээрэй.

могой хулгана үнэг



4 Зараа яагаад уйлсан бэ?

5 Хулганы зараад хэлсэн үгийг уншаарай.

Чи хулганыг ямар зантай гэж бодож байна вэ? Яагаад?

6 Хулгана өөрийнх нь амийг аварсан зараад юу гэж хэлсэн бол? Төсөөлөн бичээрэй.

